



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

“Улаанбаатар бүк” ХК-ийн
өрийг хувьцаагаар солих тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 25, 42 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар бүк” ХК-ийн нэмж гаргах нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 187,200 /нэг зуун наян долоон мянга хоёр зуу/ ширхэг энгийн хувьцааг бүртгэн тус компанийн нийт гаргасан 1,315,475 /нэг сая гурван зуун арван таван мянга дөрвөн зуун далан тав/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т үүрэг болгож, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан нэмж гаргаж буй хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авахыг санал болгох үнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээс доошгүй байхаар тогтоох, уг эрхийг хэрэгжүүлэх ажлыг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш хуульд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, “Улаанбаатар бүк” ХК /Мирзоев.Р.Г/-д тус тус үүрэг болгосугай.

3. Компани нэмж үнэт цаас гаргах шийдвэр гарган Хороонд бүртгүүлсэнтэй холбоотойгоор “Улаанбаатар бүк” ХК-ийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх арга хэмжээг Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногийн дотор тус Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Улаанбаатар бүк” ХК /Мирзоев.Р.Г/-д үүрэг болгосугай.

4. “Улаанбаатар бүк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах болон шаардах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг “Улаанбаатар менежмент” ХХК-иас тус компанийн олгосон нийт 7,244,640,000.00 /долоон тэрбум хоёр зуун дөчин дөрвөн сая


000971

зургаан зуун дөчин мянга/ төгрөгийн зээлтэй нэгж хувьцааг 38,700 төгрөгөөр тооцон хувь тэнцүүлэн эзэмшүүлж, өмчлөх эрхийг баталгаажуулахыг “ҮЦТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д зөвшөөрсүгэй.

5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Улаанбаатар бүк” ХК /Мирзоев.Р.Г/-д үүрэг болгосугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ /-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА